



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг зөрчиж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 276.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 552 дугаар тогтоолоор батлагдсан “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байрны их засварын ажилд 988.0 сая төгрөгийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр гэрээний үндсэн дээр зарцуулсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчиж 8.8 сая төгрөгийн арга хэмжээг бүрдэл дутуу баримтаар санхүүжүүлсэн зэрэг нийт 1,283.2 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэрт санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж, дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3-д “Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна” гэсэн заалтыг мөрдөж, зорилтот түвшингийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахыг таслан зогсоох;

2.4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлж, шалгуулах;

2.5 Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан ажиллаж, биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэрт “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах контрактын гэрээний 2.18, 6.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1 дэх хэсэгт заасны дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.


4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц. ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын  
газрын 2020 оны 05 дугаар сарын 05-ны  
өдрийн 05 дугаар тогтоолын хавсралт

**Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт**

| № | Зөрчил, дутагдлын утга                                                                                     | Хариуцах эзэн                                         | Дүн<br>/мян.төгрөг/ | Зөрчил дутагдлыг<br>арилгах талаар авч<br>хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                                                                                |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------|---------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Үндсэн баримтгүй зарцуулсан хөрөнгө                                                                        | Захирал Б.Наран-Идэр<br>Ерөнхий ня-бо<br>Д.Алтанчимэг | 8,831.60            | Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах |
| 2 | Худалдан авах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, сонгон шалгаруулалт явуулаагүй худалдан авалт | Захирал Б.Наран-Идэр<br>Ерөнхий ня-бо<br>Д.Алтанчимэг | 276,435.70          | Холбогдох журмыг мөрдөж ажиллах                                                                                                                                                                                  |
| 3 | Эрх бүхий байгууллагаас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй их засварын ажил             | Захирал Б.Наран-Идэр<br>Ерөнхий ня-бо<br>Д.Алтанчимэг | 998,021.80          | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах                                                                                                                                                    |
|   | <b>Дүн</b>                                                                                                 |                                                       | <b>1,283,239.10</b> |                                                                                                                                                                                                                  |